

“МЕНТАЛИТЕТ” ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН УТГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛД

Товч утга: “Менталитет” гэдэг ойлголтын талаар эдүгээ дорвитой судалсан бүтээл байхгүй байгаа боловч энэ асуудлыг сэтгэлзүй, социологи, философи, соёлзүй болон нийгмийн бусад салбаруудад тодорхойлох, томъёолох оролдлого хийгдсэн байдаг.

Менталитет нь өнөө үед оюун ухаан, ухаан бодол, сэтгэлгээ, сэтгэлгээний хэв маяг гэдэг ойлголтуудыг нэгтгэхээс гадна хүмүүсийн үйл ажиллагааны чухал хэсгүүд болох ухаан, соёл, сэтгэцийн төлөв байдал, ухамсар г.м. зүйлийг системчилж буй хүчин зүйл болж байгаа юм.

Уг асуудал нь философич, социологч, улс төрч, түүхч, сэтгэл судлаачдын анхаарлыг их татаж байсан ч одоо хирнээ нэгдсэн тодорхойлолт байхгүй байгаа билээ. Дэлхийн даяарчлалын үйл явц улам гүнзгийрч байгаа өнөө үед “менталитет”-ын талаар судлах шаардлага улам нэмэгдэж байна. Иймд менталитетийн тухай зарим судлаачдын үзэл бодлыг ангилах оролдлого хийсэн юм.

Түлхүүр үг: “оюун ухаан”, “ухамсар”, “ухамсарлагдаагүй”, “менталитет”, “оюунлаг”, “бие хүн”, “хамт олон”, “угсаатан”.

Уг ойлголт нь өнөө үед хүмүүнлэгийн ухааны олон салбарыг хөндөж байгаа бөгөөд судлах шаардлагатай байгааг дараах байдлаар тайлбарладаг юм. Нэгдүгээрт, хүний ухамсарт үйл ажиллагаа нь хүн төрөлхтний одоо ба ирээдүйн хөгжлийн чухал тодорхойлогч хүчин зүйл болж байгаа. Хоёрдугаарт, ард түмэн бүр гоо зүйн хөгжлийн онцлогтой холбоотой өөрийн гэсэн сэтгэлгээний хэв маяг, нийтлэг оюунлаг санаатай байдаг. Даяарчлалын процесс өдөр бүр улам гүнзгийрч хүн төрөлхтний үйл ажиллагааны бүх хүрээнд нэвтрэн орсноор социумуудын хоорондын харилцаанд нөлөөлж оюуны интеграцийг хөгжүүлж байгаа явдал нь менталитетийг судлах, түүнийг тодорхойлох өөр нэг шаардлага болж байгаа юм. Менталитет ба түүний судлахуй нь ертөнцийн нэгдсэн орон зайд янз бүрийн социумуудын философи - аксеологийн үндсүүдийг ойртуулснаар оюунлаг үнэлэмжийг харилцан ойлгуулах, баяжуулах арга замыг хайхад тусалж хувийн болон хамт олны субъектийн төлөв байдлыг урьдчилан тооцоолон гаргаж чадсанаар амьдралын тодорхой байдал ба үйл ажиллагаанд нь хандах хандлагыг тайлбарлах боломжтой болж байгаа юм.

Менталитет гэдэг үг нь франц хэлний “mentalite”, англи хэлний “mentality”, “mens” (mentis) гэдэг латин үгнээс гаралтай бөгөөд “ухаан”, “сэтгэлгээ”, “сэтгэлгээний хэв маяг”, “оюун санаа”, “бие хүн буюу бие хүмүүсээс бүрдсэн бүлгийн ухамсарын шинж чанарыг тодорхойлогч” гэх мэт утгыг илэрхийлдэг гэж үздэг боловч сүүлийн үед “

менталитет “ буюу “ **ментальность** ” гэдэг ойлголтыг янз бүрийн байдлаар тодорхойлж байна. Зорилго ба зорилт нь ямар шинж чанар дээр тулгуурлаж байгаагаас хамаарч менталитетийг сэтгэлзүй ба нийгмийн түүхийн үүднээс тайлбарладаг хандлага байдаг юм.

а) “**Менталитет**” – ийг гол төлөв сэтгэлзүйн үүднээс тайлбарласан байдгийн нэг жишээ бол И.Г. Дубовын “ Феномен менталитета: психологический анализ ” өгүүлэл юм. И.Г. Дубов оросын болон гадаадын судлаачдын дэвшүүлсэн ойлголтонд дүн шинжилгээ хийж дараах тодорхойлолтыг санал болгожээ. Үүнд :

-“ *менталитет* ” гэдэг нь тодорхой соёлд оршиж буй хүмүүсийн интеграль тодорхойлолт бөгөөд энэ нь тэдний ертөнцийн тухай ерөнхий төсөөллийг илэрхийлэх ба түүнд нөлөөлөх өвөрмөц онцлогийг тусгадаг”;

-“ философийн болон соёлын бүтээлүүдэд менталитетийг тодорхой үед амьдарч буй бүлэг хүмүүсийн байгаль орчин, нийгмээ төсөөлөх, ухаарах сэтгэлгээний цогц, түүхэн болон нийгмийн үйл явцад нөлөөлдөг нийгмийн сэтгэлзүйн өвөрмөц хэв маяг юм”;

-“ *менталитет* ” нь оюун ухааны үзэгдлийн хувьд нийгмийн ухамсараас өөр байдаг бөгөөд зөвхөн том хэмжээний бүлэг хүмүүс болох нийгмийн давхарга, этнос, үндэстний нийгмийн ухамсарын харьцангуй онцлогийг тодорхойлдог юм ;

-“ *менталитетийг* өргөн хүрээнд авч үзвэл : энэ нь тодорхой соёлын орчинд амьдарч буй уг соёлыг илэрхийлэгч хүмүүсийн эдийн засаг, улс төрийн хүчин зүйлсээр тодорхойлогддог сэтгэлзүйн онцгой шинжүүд юм;

-“үгийн гарлын хувьд менталитетийн агуулга нь когнитив хүрээнд хамаарагддаг ба судлагдаж буй бүлэг хүмүүсийн эзэмшсэн мэдлэгээр тодорхойлогдоно. Мэдлэг, итгэл үнэмшил хоёр нь менталитетийн суурь болох ертөнцийг үзэхүйн төсөөллийг бүрдүүлж уг бүлэг хүмүүсийн зонхилж буй хэрэгцээ, хамт олны ухамсарлагдаагүй сэтгэцийн хэв маягийн зэрэгцээ үнэлэмжийн хэмжүүрийг тодорхойлдог юм

И.Г. Дубов дээрх тодорхойлолтуудын зонхилж буй шинжүүдэд дүн шинжилгээ хийснээр уг ойлголтын тухай сэтгэлзүйн үүднээс тайлбарласан байдаг. Тэрээр “менталитет нь хүмүүсийн амьдралын сэтгэлзүйн онцлогийг илэрхийлдгийн хувьд тухайн нийгмийн мэдлэг, итгэл үнэмшил дээр үндэслэсэн ертөнцийг үзэхүй, үнэлгээ, хэв маяг, үзэл бодлын системээр илэрхийлэгддэг ба үнэлэмжийн шатлал тогтоодог, зонхилж буй хэрэгцээ нь хамт олны ухамсарлагдаагүй архетипуудын хамт тус бүлгийн төлөөлөгчдийг тодорхойлдог үзэл бодол, сонирхол, авьяас билэг болон нийгмийн бусад үзүүлэлтийг мөн илэрхийлдэг “(1) гэжээ.

“Менталитетийг “ мөн сэтгэлзүйн үүднээс тайлбарладаг оросын судлаач Б.А. Душковын үзэж байгаагаар уг ойлголт нь “ хувийн болон хамт олны ухамсарын онцгой төвшинг тодорхойлдог тул энэ утгаараа сэтгэлгээний өвөрмөц хэв маягийг илэрхийлдэг “ гэжээ (2).

Судлаачид ард түмний сэтгэлзүйн хөгжлийг үнэлэх хүчин зүйлүүдийг тодорхойлох оролдлого хийж байсан . Ард түмэн бүр өөрийн анатомийн онцлогуудтай ижил, тогтмол өвөрмөц оюунлаг бүтэцтэй учир

үзэл бодол, итгэл үнэмшэл, мэдрэхүй ба урлахуйг бий болдог гэж Лебон үзжээ. Өөрийн бүтээлдээ Лебон сэтгэлзүйн онцлогууд нь үндэсний зан төлөвийг бүрэлдүүлдэг гэж тэмдэглээд “соёл иргэншлийг бий болгодог янз бүрийн элемент болох : хэл, үзэл бодол, итгэл үнэмшил, урлаг, уран зохиол нь тэднийг бүтээсэн хүмүүсийн оюуны /сэтгэцийн/ илрэл юм” (3).

Ард түмний сэтгэлзүйн талаарх өөрийн бодролоо В.Вундт дэвшүүлжээ. В.Вундт, ард түмний менталитетийн асуудлыг судлахад домог, шашин, урлаг болон соёлын бусад үзэгдлүүдийг ашигладаг шинлэх ухааны өвөрмөц арга зүйг боловсруулан дэвшүүлсэн юм. Амьдралын орон зайд соёлын ба оюуны бүтээгдхүүн болох хэл, домог, заншил “оюуны нэгдсэн бүлэг” бүрэлдэж үйл ажиллагаагаа явуулснаар угсаатны сэтгэхүйн нэгдмэл бий болдог хэмээн үздэг юм. “Оюун санааны нийтлэг” гэдгийг тайлбарлахын тулд Вундт “олон түмний санаа” гэдэг ойлголтыг илэрхийлж буй “оюуны харилцааны шинж” гэсэн ойлголтыг дэвшүүлсэн. Вундт нь олон түмний хамтын бүтээлч үйл ажиллагааг судлах хэрэгтэй гээд үүнийг хийсвэр ба тодорхой гэсэн хоёр чиглэлээр хийж болно гэжээ. Нэгдүгээр чиглэл: домгийг нь олон түмний чанар, мэдрэхүй; заншлыг нь – ёс зүйн зарчим гэсэн ойлголтууд дээр тулгуурлан бие хүмүүсийн харьцааг судлах; хоёрдугаар чиглэл бол эхний аргын үр дүн дээр үндэслэн тодорхой үндэстэнг судлахыг хэлж байгаа юм. Гэвч ерөнхий сэтгэл зүйн хэмжээнд соёлын нөлөөний талаар Вундтын гаргасан саналуудыг гүнзгийрүүлэн судлаагүй боловч дээрх санаануудыг Германы түүх соёлын чиглэлийг баримтлагч нар өөрийн түүхийн загварт оруулан тайлбарлажээ (4).

З.Фрейдийн үзэж байгаагаар ард түмний сэтгэлзүй нь тоймгүй их хэмжээний хувийн асуудлуудаас бүрэлддэг ба энэ нь судлаачдын өмнө мөн л тэр хэмжээний зорилт дэвшүүлж байгаа гэжээ. Эдгээр асуудлуудын нэг бол ухамсарлагдсан, ухамсарлагдаагүй үзэгдэл юм. Ухамсарлагдаагүй үзэгдэл нь ухамсрын адил хүний сэтгэл зүйн өвөрмөц илрэлийн хувьд хүний нийгмийн амьдрахуйн нөхцлөөр тодорхойлогддог ба хүний тархинд ертөнцийн нэг хэсгийг тусгадаг гэж тайлбарладаг.

Уг үзэгдлийг анх судалсан З.Фрейд “хүний дур сонирхол нь нийгмийн хэвшсэн байдалд харшилж буй учраас ухамсарлагдаагүй хэсэгт шахагдан гардаг гэжээ. Нөгөөтэйгүүр, ухамсарлагдсан зүйлүүд нь янз бүрийн хүчин зүйлийн нөлөөнөөс болж ухамсарлагдаагүй хэсэгт ордог ба шаардлагатай үед эргэн ухамсарлагддаг, өөрөөр хэлбэл завсрын хугацаанд нуугдмал байдалд байсан учир тодорхойлох боломжгүй гэвч хэрэгцээт үеэд эргэн ухамсарлагдан гарч ирдэг гэж Фрейд үздэг юм. Түүнчлэн “нуугдмал боловч эргээд ухамсарлагдаж болох, бие даан болон бусад зүйлүүдгүйгээр ухамсарлагдах боломжгүй гэж” (5) хувааж ухамсарлагдаагүй хоёр төрлийн үзэгдэл байгаа гэж үздэг юм.

К.Юнг уг асуудлын талаар өөрийн санаа бодлоо илэрхийлж тодорхой нөлөө үзүүлсэн юм. Тэрээр өөрийн бүтээлдээ менталитетийн үндэс болох “хамт олны ухамсарлагдаагүй” ба “архетип” гэдэг үзэл санааг дэвшүүлж “хамт олны ухамсарлагдаагүй” үзэгдлийн агуулгыг хүн төрөлхтний нийтлэг анхдагч дүрслэлүүд бүрэлдүүлдэг ба архетипуудыг шууд мэдрэх боломжгүй

бөгөөд зөвхөн гадаад объектонд нөлөөлж буй тусгалаар /проектээр/ нь ухамсарладаг гэжээ.

1860 онд Германы эрдэмтэн М.Лацарус Х.Штейталь нар "олон түмний сэтгэц" гэдэг шинжлэх ухааны шинэ чиглэлийг тунхаглан зарласан юм. Тэд тодорхой үндэстэнд хамаарч буй хувь хүний сэтгэхүйн ижил байдлыг "олон түмний сэтгэц" гэж үзэж тэдний ухамсарын агуулгыг тайлбарлахад хэл, домог, ёс зүй ба соёлыг харьцуулан судлах замаар тайлбарлах хэрэгтэй гэжээ.

Америкийн түүх соёлын чиглэлийг баримтлагч эрдэмтэн Ч.Жадд, Вундтын санааг үргэлжлүүлэн хөгжүүлж, хэл, хөдөлмөрийн зэмсэг, урлаг г.м мянга мянган жилээр хуримтлагдаж ирсэн элементүүд нь үндэсний ухамсар болон сэтгэхүйг төлөвшүүлдэг бөгөөд үүнийг "нийгмийн хуримтлагдсан капитал" гэж нэрлэжээ.

Менталитетийн талаар зарим судлаачид нийгмийн түүхийн үүднээс тайлбарласан байдаг.

"Сэтгэц" ба "олон түмний сэтгэц" гэсэн ойлголтуудыг хөгжүүлэхэд Францын "Анналын сургууль" хэмээх чиглэл их хэмжээний хувь нэмэр оруулсан юм. Энэ сургууль нь менталитет гэдэг ойлголтыг нийгмийн түүхийн үүднээс дэвшүүлснээр угсаатны сэтгэхүйд эзлэх байр суурийг тодорхойлох оролдлого хийсэн юм. Уг чиглэлийн эхийг тавьсан Марк Блок, Люсьен Февр нар ард түмний дунд болж буй үйлдлүүд нь тэдний ухамсар, ертөнцийг мэдрэхүйн гүн илрэл гэж үздэг. Февр ард түмний санааг сэтгэлзүйн үүднээс үзэх хэрэгтэй гэдэг бол Марк Блок социологийн чиглэлийг дэмжиж байснаар Дюркгеймын зарим саналуудыг зөвшөөрч байв. Тэрээр "гайхамшгийг бүтээгч хаад ноёд", "Феодлын нийгэм" гэдэг бүтээлүүддээ "мэдрэх ба сэтгэхүйн аргуудын" тухай дурдаж соёлч зан төлөвийн нийгмийн ялгаварт анхаарлаа төвлөрүүлжээ.

Менталитет гэдэг асуудлыг судлахад эрдэмтэн Ле Гофф өөрийн анхаарлаа хандуулж байжээ. Ле Гоффын үзлээр түүхийн шинжлэх ухаан нь хоёр зүйлээс бүрддэгээрээ өвөрмөц юм гэжээ. Нэг нь "бодит байдал" нөгөө нь уг байдал нь өнгөрсөн үеийн хүмүүст өөрийнхөө тухай үлдээсэн "төсөөлөл" юм. Ертөнцийн тухай ерөнхий төсөөлөл буюу менталь төсөөллийн системийг Ле Гофф (воображаемое) "төсөөлөгдөхүй", (чувственное) "мэдрэхүй", (символическое) "билэгдэл" зэрэг үзэгдлүүдээс гадна үнэлэмж, үзэл суртал дээр үндэслэн тайлбарлаж байв. Ле Гофф нь дунд үеийн хүмүүний ухамсарт төлөвшсөн зан төлөвийн тогтвортой шинж, өдөр тутмын нийтлэг ба ухамсарлагдаагүй зүйлүүдийг үндэслэсэн дундад зууны үеийн менталитетийн сан байдаг гэж үздэг байв. Тус санд нь "тодорхойг" хийсвэрээс ялгахад нэн хүндрэлтэй ба тодорхой хийсвэр хоёрын үелэн байрласан байдал нь дундаж үеийн хүмүүний мэдрэхүй болон менталитетийн үндсийг бүрэлдүүлдэг" гэж тайлбарлаж байсан байна (6). Иймд XX зууны эхэнд шинжлэх ухааны чиглэлээс хамааран олон төрлийн хүчин зүйлүүдийн аль нэгэн давамгайлж буй төрлөхийн хэмжигдэхүүн болох "олон түмний санаа" гэдэг төсөөлөл шинжлэх ухаанд бий болсон гэж үздэг.

Түүхэн сэтгэлзүй ба соёл-антропологийн чиглэлүүдийн төлөөлөгчдийн дэвшүүлсэн менталитетийн тухай анхны тайлбар нь аливаа нэгэн бүлгийн "сэтгэхүйн тоноглол"-ын тухай өгүүлсэн байдаг ба үүгээрээ нийгмийн орчин болон өөрийгөө мэдрэх боломжоор хангагдаг гэж үздэг байв. Энэ нь хүмүүжлийн үйл явцад суурьлагддаг ба соёлын нөхцөлт байдлаас шалтгаалан угсаатны ухамсарын "амьд" хэрэглээ болдог гэж үздэг байжээ.

Дээрх онолыг "Анналын сургуулийн" залгамжлагч Жорж Дюби үргэлжлүүлэн боловсруулсан юм. Ж. Дюби нь янз бүрийн нийгмийн бүлэгт ижил бус байдаг дүрслэл ба төсөөллийн системийг менталитет гэж үздэг байв.

"Нийгмийн бүх харилцаа нь хүмүүжил сургалтын үйл явц болон эдийн засгийн тодорхой нөхцөлийн үр дагавараас шалтгаалан үеэс үед дамждаг уг "дүрслэлийн системийн" үүрэгтэй ижил төлөвшдөг" гэж Дюби үздэг. Ийм учраас аливаа түүхэн үйл явдлын мөн чанар ба утга нь эрдэмтэн судлаачдын баримталж буй системээс хамаарч байдаг гэж тайлбарлаж байжээ. Соёлын орчин, цаг агаар, эрдэмтдийн хувийн онцлогоос шалтгаалан янз бүрийн дүгнэлт гардаг учир угсаатны ухамсарыг төлөвшүүлдэг оршин буй орчин, бие хүн хоёрын харилцаа нөлөөг судлах шаардлага гарч ирж байгаа юм. "Менталь удирдамжийг судлахгүйгээр нийгмийн нэгдмэл түүхийг бий болгох боломжгүй" гэж Дюби өөрийн бүтээлдээ бичжээ (7).

Оросын түүхч Гуревич А.Я. "Түүхэн синтез ба "Анналын" сургууль" гэдэг бүтээлдээ менталитетийн ойлголтын агуулгыг түүхийн шинжлэх ухааны үүднээс тайлбарласан юм. "Менталитетийн түүх нь тод байдлаар илэрхийлэгдээгүй ба томъёологдоогүй нийгмийн ухамсарын нууц шинжүүд юм" гэжээ. Гуревич нь "мен-талитетийн түүх гэдэг нь нэг талаас тодорхой нийгмийн орчинд "урсаж" буй ухаан санаа, үзэл бодлын ба үнэлэмжийн чиг баримжааны тодорхой бус илрэл, ухамсарын чадвар, нөгөө талаас "хувийн бус тогтвортой хандлага" гэж тайлбарлаж байжээ (8). Сүүлийн үед нийгмийн түүх судлаачдийн үзэж байгаагаар түүхэн бодит байдлын цогц дүрслэлийг зөвхөн тухайн үеийн хүмүүс өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байсан төсөөлөл, үнэлэмжээр нь тодорхойлоход хангалтгүй гэжээ. Тэдний үзэж байгаагаар менталитетийн төсөөлөл, үнэлэмжийн агуулга нь юугаар тодорхойлогдож байгааг судлах шаардлагатай бөгөөд энэ нь менталитетийн "үндсийг" тодорхойлоход тусалж үүслийг тайлбарлахад тус болно гэж үздэг юм.

Менталитетийг судлах өөр нэг хандлага нь – философийн хандлага юм. Уг хандлага нь менталитетийг "хувийн ба нийгмийн ухамсар", "өөрийн ухамсар", "ертөнцийг үзэхүй", "ертөнцийн дүрслэл" г.м. категориуд хэрэглэн тайлбарладаг юм.

XX зууны сүүлчээр философи ба нийгмийн шинжлэх ухаан антропологийн асуудалд анхаарлаа төвлөрүүлж байсан нь "менталитет" гэдэг ойлголт тодорхой хэмжээгээр нөлөөлсөн гэж үзэж болох юм. "Менталитет" гэдэг нь янз бүрийн нийгмийн давхарга, үндэс угсаатны хувьд ялгаатай бүлэг хүмүүс буюу хувь хүний ертөнцийг үзэхүйн өвөрмөц илрэл

ба уг илрэлээр илэрхийлэгдэж буй ертөнцийн дүрслэл нь дотоод сэтгэцийн гүнд төлөвшдөг гэж үздэг юм. Энэ нь хүний сэтгэцийн гүнд үүсвэрлэн гарснаар философийн хөгжлийн явцад ямагт анхаарал татаж байдаг хүн ба ертөнц гэдэг ойлголтуудын харьцааг улам гүнзгийрүүлэн тайлбарлах шаардлага зүй ёсоор тавигдсанаар антропологийн асуудлууд цоо шинэ төвшинд гарч ирж байна гэж үзэж болох юм. Хүний феноменд тавьж буй анхаарал нь юуны өмнө өдөр тутмын оршихуйн үйл явцад үүсэж буй амьдрахуйн асуудлуудыг шийдвэрлэх хувь хүний (индивид) хэрэгцээтэй холбон үздэг. Хувь хүн оршиж буй ертөнцөө ойлгох оролдлого хийх үеэс эхлэн өөрийгөө ухаарч эхэлсэн гэдэг. Үүний нэг жишээ нь домгийн сэтгэлгээ юм. "Нийгэмшлийн эхэн үеийн хүмүүн төрөлхтний ертөнцийн үзэхүйд домгийн сэтгэлгээний арга барил зонхилж" байсан тул "байгаль нийгмийн юмс үзэгдлийг хүмүүнчилсэн загвараар төсөөлж байсан". "Юмс үзэгдлийн мөн чанарыг ерөнхий ойлголт, категороор илэрхийлэх танин мэдэхүйн төвшинд хүмүүн төрөлхтөн хараахан хүрээгүй байсан цаг үеэд амьдархуйн туршлагынхаа хэмжээнд хүний үйл ажиллагааны загвараар ертөнцийг төсөөлж, овог аймгийн зохион байгуулалтын бүтэц, харилцааны хэлбэрийг бодит байдлын бүхий л хүрээнд хамаатуулан сэтгэж байсан" (9) иймд уг сэтгэлгээ (менталитет) нь амьдрахуйн явцад ухамсарын ухамсарлагдаагүй хэсэгт хуримтлагдаж шаардлагатай тохиолдолд эргэн ухамсарлагдан сэргээгдэж амьдрахуйн удирдамжийн үүргийг гүйцэтгэдэг байсан гэж үзэж болох юм.

Гераклит, Сократ, Платон болон эртний грекийн олон сэтгэгчид "хүний сэтгэцийн өвөрмөц онцлогийн" тухай өөрийн санаа бодлоо дэвшүүлж, өөрийн шавь нартаа уламжлан үлдээснээр сэтгэц гэж нэрлэгдэж буй ухамсарын гүн дэх үзэгдлийн тухай өөрийн бодролуудыг тасралтгүй хөгжих боломжоор хангасан гэж үздэг юм. Гиппократ "Агаар, ус, газрын тухай" бүтээлдээ "ард түмний сэтгэц" –ийн ялгаа нь газар зүйн байрлал, цаг уур, байгалийн хүчин зүйлүүдээс хамаардаг гэж тайлбарлажээ.

Аристотель "Сэтгэцийн тухай" гэдэг бүтээлдээ сэтгэц, түүний агуулга, мэдрэхүй ба ой тогтоолтын үзэгдлийн тухай онолыг боловсруулж, сэтгэц нь амьдрахуйд утга / смысл / ба чиглэлийг нь өгдөг зохион байгуулагч хэлбэр гэж нэрлэжээ. Хүн бол "улстөрийн амьтны" хувьд хамгийн энгийн төвшинд ч ямар нэгэн хэмжээний зохион байгуулалттай байх ёстой ба "нийтлэг санаа" боловсруулахад мөн ямар нэгэн хэмжээний нийтийн ухамсартай байх ёстой гэжээ.

Шинэ үеийн философийн төлөөлөгчдийн тоонд багтдаг Бэкон "Шинэ органон", Гоббс "Левиафан" бүтээлүүддээ мөн рационализмын философийг үндэслэгч Рене Декарт нар хүний ухамсарын нууцыг тайлах талаар өөрийнхөө анхаарлаа хандуулж байжээ. Судлаачид сэтгэхүйг ухамсарт их үүрэг гүйцэтгэдэг гэж үзэж байсан ба энэ хандлага нь цаашид европын философийн рационалист болон эмпирик чиглэлд их нөлөө үзүүлсэн гэж үздэг юм.

Декартын үзэж байгаагаар субъект өөрийн дотоод ертөнцийн агуулгыг дотоод мэдрэхүйгээр хүлээн авж буйг өөрийн ухамсар гэж нэрлэсэн байна. Шинэ мэдлэг ба өмнө нь байсан мэдлэгийн хоорондын харьцааг Декарт

рефлекси гэж нэрлэж өөрийн ухамсар нь түүн дээр үндэслэдэг гэж үзэж байжээ. Декарт оршихуйн тухай сургаалдаа субстанции гэдэг ойлголт оруулж энэ нь уг сургаалын төв ойлголт нь болсон юм. Уг сургаалийн дагуу хүн Бурхнаас заяагдсан “биелэг” ба “оюунлаг” гэдэг хоёр субстанции байдаг гэж үзэж байжээ. Оюунлаг субстанцид анхнаасаа хамаарч байсан учраас төрөлхийн санаа байдаг гэж Декарт үзэж байжээ. Дээрх санааг тэрээр ойлголт ба аксиом – бодомжууд гэж хоёр хувааж үзжээ. Декартын төрөлхийн санааны тухай сургаал нь судлаачдын үзэж байгаагаар бодит байдлыг бүрэн илэрхийлээгүй боловч шинэ үе өнгөрсөн үеэсээ туршлага ба мэдлэгийг шингээн үлдээдэг мөн зарим мэдлэг нь төрөх үед нь нөхцөлт бус хэлбэрээр өгөгдсөн байдаг гэж үздэг юм. Гэвч уг мэдлэгийг бүрэн хэмжээгээр нь мэдлэг гэж ойлгож болохгүй ба тодорхой хэмжээний мэдээлэл гэж ойлгож болох юм гэжээ.

Газар зүйг гол тодорхойлогч хүчин зүйл гэдэг ойлголтын үүднээс Ш.Монтескье, дараа нь Д. Юм нар “ард түмний сэтгэц” гэдэг ойлголтыг улам өргөжүүлэн хөгжүүлжээ.

Марксизм нь ухамсарын тухай судалгаанд тусгай байр суурь эзэлдэг юм. Марксизмын онолын дагуу эдийн засаг гол үүрэг гүйцэтгэдэг ба “ухамсар нь оршихуйг бус нийгмийн оршихуй нь ухамсрыг тодорхойлдог” гэж үздэг юм. Марксын үзэж байгаагаар хүнд төрөлхийн санаа байдаггүй ба илэрхийлэгдэж байгаа бодол нь орчин болон сонирхлыг нь баримталж буй нийгмийн хэсгийн нөлөөний улмаас бий болдог гэжээ. Хүмүүс зөвхөн хоорондоо харилцахаас гадна хүнийссэн эд зүйл, нийгмийн бүтэцтэй харилцдаг юм. Энэ харилцааны үр дүнд “хувь хүн нийгмийн амьтны” (10) хувьд нийгмийн соёл, түүхийг эзэмшин авдаг гэж тайлбарлаж байжээ. Иймд менталитетийн агуулга, түүний үүсэл, бие хүний хувийн ертөнцийн үзэхүй, төлөв байдлын өвөрмөц шинжүүдийг судлах шаардлага байхгүй байсан юм.

Ард түмний болон хувь хүний ухамсарт болж буй түүхэн өөрчлөлтүүд нь ухамсрын талаархи үзэл бодлыг цоо шинэ байр сууринд тавьж өгсөн юм. Гэвч ухамсар гэдэг ойлголтыг менталитеттэй адилтгаж болохгүй гэж үздэг. Учир нь менталитет амьдархуйн янз бүрийн хэсгийн хувийн ба нийгмийн харилцааны гүн дэх хүчин зүйлүүдийг тодорхойлдог, өөрөөр хэлбэл менталитет нь хувийн ба нийгмийн ухамсарын хүчин зүйлийн үндэс болдог гэж тайлбарладаг юм. Менталитет хүний оршихуйн хувьд зөвхөн когнитив орчноор хязгаарлагддаггүй ба үүгээрээ хувийн ба нийгмийн ухамсраас ялгаатай байдаг. Менталитетийг юуны өмнө нийгмийн философийн категори гэж үздэг ба өргөн утгаар нь ёс суртахуун, моралийн категори гэдэг юм. Хүн өөрийнхөө амьдархуйн харьцаа, зан төлөвийг ухамсраараа эсвэл дотоод ухамсраараа зөвхөн бие хүний ухамсар, өөрийн ухамсар, дотоод ухамсрын төвшинд бус нийгмийн орчинд төлөвшдөг менталитетийн хүчин зүйлийн үндэс ба үнэлэмжтэй харьцуулан үздэг юм. Социумын менталитет ард түмний төлөв байдалд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг юм. Ингэснээрээ тодорхой социумуд ба хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжилд геободлогын ба нийгэм-эдийн засгийн түүхийн хэмжээний түлхэц өгдөг юм.

РЕЗЮМЕ

В данной статье мы сделали попытку проанализировать некоторые подходы к проблеме менталитета, которая в последнее время всё больше и больше получает статус самостоятельности.

Изучение менталитета имеет огромное значение, потому что в отличие от индивидуального и общественного сознания менталитет характеризуется устойчивостью, стабильностью и поэтому сохраняется в долговременной социальной памяти, предопределяя содержание и структуру социально-генетического кода и личности и общества. Использование данного понятия в монгольском языке без перевода объясняется отсутствием аналогичного понятия или употреблением понятия не раскрывающего, на наш взгляд, полностью содержание этого объёмного по выражению понятия.

Ном зүй:

1. Гершунский Б.С. Философия образования для XXI века. Издательство "Совершенство". М., 1998 с. 113).
2. Душков Б.А. Психосоциология менталитета и нооменталитета. Екатеринбург. Деловая книга. С.13).
3. Лебон Г. Психология народов и масс СПб., 1995, с. 66
4. Вундт. В. Психология народов. Т.3. СПб 1900-1920. с. 292-295. З.Фрейд. Психология бессознательного. Новосибирск. 1997. с.508.
5. Ле Гофф Цивилизация Средневекового Запада. М. Прогресс. 1992. с. 311-312
6. Горюнов ВЕ. Ж.Дюби История ментальностей // История ментальностей, историческая антропология М.: РГГУ, 1996 с. 19
7. А.Я.Гуревич Исторический синтез и Школа "Анналов". М., 1993. с.10-11
8. Г.Лодой. Домгийн сэтгэлгээ ба ертөнцийг үзэхүй. Эрдэм шинжилгээний бичиг. № 185 (12) х.14.
9. Маркс К. Экономическо- философские рукописи 1844 года. Маркс К., Энгельс Ф. Соч., т.42 с. 119